

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРААС 2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН  
АЖЛЫН ТАЙЛАН

УДИРТГАЛ

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Монгол улсын шүүхийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.2, 86 дугаар зүйлийн 86.1.8 дахь хэсэгт заасныг үндэслэн тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарт танилцуулан Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж байна.

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар 2024 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчтай Монгол улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 86 дугаар зүйл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 сарын 17-ны өдрийн 28 дугаартай тогтоолоор батлагдсан “Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.2-д заасан 5 үндсэн чиг үүргийн хүрээнд “Шүүхийн бие даасан байдлыг хангах”, “Шүүхийг хүний нөөцөөр хангах”, “Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах”, “Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах”, “Мэдээллээр хангах” гэсэн бүтэц бүхий нийт 73 ажил төлөвлөн хууль хяналтын болон, орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, шүүхийн хүний нөөцийг шинэчлэх, шүүгчийн үр нөлөөтэй, бүтээмжтэй хариуцлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар тайлангийн хугацаанд шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, шүүх, шүүгчийн аюулгүй байдал, шүүгчийн хараат бус байдлыг ханган ажиллаж, тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг Эрүү, иргэний нэгдсэн системд тохируулан өөрийн court26.kho.gov.mn цахим хуудаст байршуулсан байна.

2024 оны 11 сарын 30-ны байдлаар иргэн аж, ахуйн нэгж байгууллагаас 175 нэхэмжлэл, Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Прокурорын газраас 61 эрүүгийн хэргийг хүлээн авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэж байна. Тус шүүхийн эвлэрүүлэн зуучлагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 50 өргөдөл, хүсэлт хүлээн авч эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр 45 өргөдөл

шийдвэрлэснээс 35 нь үр дүнтэй болж талууд эвлэрсэн байна. Мөн зөрчлийн 241 материал хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Тамгын газар нь шүүхийн шинэчлэлийн бодлого, түүний хэрэгжилтийг хангуулах, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шуурхай шийдвэрлэх чиглэлээр тусгагдсан ажлуудын биелэлтийг хангах, хэргийн хөдөлгөөний стандартыг чанд хэрэгжүүлэн ажиллаж, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс баталсан хөтөлбөр, журмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, шүүхэд үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, шүүхийн захиргааны ажилтнуудын ёс зүйг сайжруулах, иргэд олон нийтэд ил тод мэдээлэл өгөх зэрэг төлөвлөгдсөн ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулан Тамгын газрын 2024 оны жилийн ажлын төлөвлөгөө, түүнд нийцүүлэн баталсан улирлын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн үндсэн үйл ажиллагаа болох шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулах, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар хандсан иргэдийн асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэхэд зохигчдын хууль ёсны эрхийг хангах, шүүхээс үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхийг зорилго болголоо. Тайлангийн хугацаанд иргэд, олон нийтээс тус шүүхийн шүүгч, шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны ажилтнуудтай холбоотой гомдол, өргөдлийг ирүүлээгүй нь Тамгын газрын ажлын үр дүн юм.

Тус шүүх нь 2024 онд хүний нөөцийн хувьд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан 22 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын мэдээлэлийн тогтолцооны систем, шүүхийн хүний нөөцийн системд шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар бүртгэн оруулж үнэн зөв оруулсан эсэх талаар танилцуулж баримтыг хууль, журмын дагуу хагас, бүтэн жилээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нараар гарын үсэг зуруулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.

Тус шүүхийн Тамгын газрын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолттой нь нийцүүлэн ажилтан тус бүрээр байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнийхээ биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна.

Мөн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор холбогдох байгууллага, иргэнтэй ажил гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

НЭГ: ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР  
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Шүүхийн үйлчилгээний стандартыг хангах, хэрэгжүүлэх чиглэлд иргэд, олон нийтэд чиглэсэн үйлчилгээний стандарт батлан мөрдүүлж Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн дүрэм, бусад холбогдох дүрэм журам, ёс зүйн хороо, зохих шатны удирдлагад гомдол гаргах процедурыг ойлгомжтойгоор тайлбарласан схем загвар бүхий мэдээллийн самбар гаргасан ба шүүхийн захиргааны ажилтны үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн өргөдөл, гомдол ирээгүй байна. Шүүхийн захиргааны ажилчдын үйлчилгээний харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэрийг цахим хуудсанд байршуулах журам, нөлөөлөлийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Шүүх, шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд цахим шуудан хэрэглэх журам, эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалд өөрчлөлт оруулах тухай, Хэргийн хөдөлгөөний хяналтын журам зэрэг журмын төслүүдэд шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нараас гаргасан саналыг хүргүүлсэн байна.

  
**ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНД**

**ХОВД АЙМГИЙН БУЛГАН  
СУМ ДАХЬ СҮМ ДУНДЫН  
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

84210 Ховд аймаг, Булган сум,  
Ховд аймгийн Булган сум дахь шүүхийн байр,  
Утас/Факс: (976) 75119175  
E-mail: Bulgan\_kho\_lg@shuukh.mn

2024-09-16 № 92  
төмөр хуудас

Санал хүргүүлэх тухай

Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалын 5.13 дугаар зүйлийн 5.13.1.Ажилтан ИХШХШТХ-ийн 751, 752-т зааснаар гаргасан нэхэмжлэл /сөрөг нэхэмжлэл/-ийг /Баримт №33, болон №36-57-ын аль нэг/ дагуу ирүүлснийг нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлох эрхийг хөндөхгүйгээр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийгдэх ажиллагааг урьдчилан шаардахгүйгээр, урьдчилан үнэлэхгүйгээр, ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүйгээр ажлын бүх өдрүүдэд, ажлын цагаар Бүртгэл №1, Бүртгэл №2-т бүртгэж, шүүхэд хүлээлгэн өгсөн хүний нэр, гарын үсгийг тайллын хамт зуруулна.

7 дугаар зүйлийн 7.1.4.Тамгын дарга түүнийг эзлэхийн амралт, өөртэй чөлөөтэй тохиолдолд хэлтсийн дарга тухайн шүүхийн шийдвэрийг цахим санд хугацаандаа бүрэн, зөв байршуулж байгаа эсэхэд хяналт тавина.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх баримтын загварын жагсаалтанд "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.6.Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих иргэн оршин суугаа газартаа буюу ажлынхаа газарт байхгүй бол уг хуудсыг түүний хамт амьдардаг насанд хүрсэн иргэн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд буюу ажлын газрынх нь захиргаа, хэргийн төлөөлөгчид хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна." гэж өөрчлөх тухай санал гаргасаныг уламжилж байна.

ДАРГА  ЦДЭЛГЭР 



  
**ХОВД АЙМГ, БУЛГАН СУМ,  
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

84210 Ховд аймаг, Булган сум,  
Ховд аймгийн Булган сум дахь шүүхийн байр,  
Утас/Факс: (976) 75119175  
E-mail: Bulgan\_kho\_lg@shuukh.mn

2024-09-20 № 14  
төмөр хуудас

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛД

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Ерөнхий шүүгч, шүүгч нарт танилцуулсан бөгөөд нэмэлт санал байхгүй болно.

ДАРГА  ЦДЭЛГЭР 



Нээлттэй шүүх танхимын дэлгэцээр шүүх хуралдааныг олон нийтэд хүргэхээс гадна шүүх хуралдаан дууссан үед Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан

шторк, мэдээллүүдийг цацан, иргэд өөрөө өөртөө үйлчлэх ухаалаг дэлгэц суурилуулж, иргэд олон нийтийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Шүүхийн үйл ажиллагаа, үйлчилгээний горимыг иргэдэд энгийн ойлгомжтой болгох зорилгоор эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон Тамгын газрын иргэдэд үйлчлэх үйлчилгээний схем зураглалыг боловсруулан иргэдийн өөртөө үйлчлэх хэсэгт байрлуулсан.

Мөн шүүхийн байрыг заасан таних тэмдэг, тэмдэглэгээг шүүхийн байрны өмнөх 3 замын уулзварт 2 цэгт байршуулсан

Тус шүүхийн “[www.court26.kho.gov.mn](http://www.court26.kho.gov.mn)” вэб хуудас болон “Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүх” пасебүүк хуудсаар онцлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж байна. “[www.court26.kho.gov.mn](http://www.court26.kho.gov.mn)” вэб хуудас нь Үндэсний дата төвөөс алдаа заасан байсан ба энэхүү вэб хуудас нь 2015 онд ашиглалтанд орж шинэчлэгдээгүй байсныг шинэчилж хэвийн ажиллагаанд оруулсан.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2019 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Шүүхийн төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-д заасны дагуу төрийн болон шүүхийн нууцад хамааруулсан нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлсийг хүлээн авч, хадгалах, хамгаалах, илгээхтэй холбоотой харилцааг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор эрх бүхий байгууллагаас өгсөн зохих зөвшөөрлийг үндэслэн, шүүхийн нууцтай холбоотой асуудлыг хариуцах ажилтанг томилон ажиллуулж байна.

Эвлэрүүлэн зуучлагч 2024 оны 1, 3 дугаар улиралуудад харьяа сумуудаар нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлан таниулж, гарын авлага материал тараан ажиллаа.



Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2022 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Хавстаст хэрэг илгээх, хүлээн авах журам”-ыг шүүхэд нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор Эрүү, Иргэний хэргийг илгээх, хүлээн авах ажлыг хариуцсан шүүхийн захиргааны ажилтанг томилон ажиллаж байна

Монгол улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар анхан шатны шүүх эрүү, иргэний хэрэг, захиргааны хэрэг маргааныг анхан шатны журмаар хамтын зарчмаар хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулна гэж заасны дагуу Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн жишиг тоо батлах тухай 2023 оны 08 сарын 31-ний өдрийн 239 дугаар тогтоолыг үндэслэн батлагдсан 319 иргэдийн төлөөлөгч нарт урилга хүргүүлж хүрэлцэн ирсэн нийт 43 иргэнд сургалт зохион байгуулж, харьяа сумуудаас сонгогдсон иргэдийн төлөөлөгч нарт гарын авлага боршур тараан ажилласан.



Эрүү, иргэний хэргийн хөдөлгөөний стандарт, болон шүүх хуралдааны нийтлэг дэг, Иргэдийн төлөөлөгчийн оролцоо эрх, үүрэг, шүүх хуралдаан оролцох, хуралдаанд тэмдэглэл хөтлөх хэргийн материалтай танилцах, дүгнэлтээ уншиж танилцуулах талаар, болон бусад асуудлаар тайлбарлан таниулж санал бодлоо солилцон арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Хэргийн хөдөлгөөний нэгдсэн удирдлагын системд эрүү, иргэн, зөрчлийн хэргийн мэдээг сар, улирал тутам үнэн зөв гарган оруулж байна.

Тус шүүхийн Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, Эвлэрүүлэн зуучлагч, Мэдээлэл технологийн мэргэжилтэн, шүүгчийн туслах нар 2024 оны 1 дүгээр улиралд харьяа сумуудаар нээлттэй хаалганы өдөрлөг, 2 дугаар улиралд хуульчийн поро боно өдөрлөг, 3 дугаар улиралд нээлттэй шүүх өдөрлөг зохион байгуулж иргэд олон нийтэд Шүүхийн иргэдийн төлөөлөгч, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, шүүн таслах ажиллагааны талаар мэдээлэл өгч гарын авлага материал тарааж зөвлөгөө өгч ажиллаа



Шүүхэд ирж буй хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоос баталсан хуваарийн дагуу Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хүлээн авч шүүгч нарт хуваарилан ажиллаж байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын гомдлоос бусад /шүүхийн тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаа, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын ёс зүй, харилцаа хандлага гэх мэт/ гомдол ирээгүй байна.

Монгол улсын Засгийн газраас баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтанд тус шүүхийн архив, бичиг хэргийн эрхлэгчийг хамрууллаа.

“Иргэн-2014” нэгдсэн системд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрийг цаг тухайд нь оруулж бүртгэл хөтлөн мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна.

Шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүх хуралдааны товыг хэргийн оролцогч болон шүүхийн иргэдийн төлөөлөгчдөд хүргэх, мэдэгдэх ажлыг шуурхай зохион байгуулж шүүх хуралдааны бэлтгэл дутуу хангасан үндэслэлээр тайлангийн хугацаанд шүүх хуралдаан хойшлоогүй байна.

Шүүхийн шийдвэр болон мэдэгдэх, гүйцэтгэх хуудас, бусад эрх зүйн баримт бичгүүдийг хэргийн оролцогчид, холбогдох байгууллага, иргэнд шуурхай хүргүүлэх ажлыг зохион байгуулж шуудан үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа.

Шүүхийн статистик мэдээ, судалгаа болон бусад байгууллага албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн дагуу шаардлагатай мэдээлэл, судалгааг батлагдсан журам, зааврын дагуу гаргаж холбогдох байгууллага албан тушаалтанд цаг хугацаанд нь хүргэж ажиллалаа.

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу шүүхийн тамгын газрын шүүхийн захиргааны ажилтан болон журам сахиулагч, харуул хуягийн үйл ажиллагааны талаар уулзалт ярилцлага, сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.



Мөн хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу бүх нийтийн амралт баяр ёслолын арга хэмжээний үед шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор

тус шүүхийн захиргааны ажилтан нар цагдаагийн алба хаагч нартай хамтран үүрэг гүйцэтгэж ажиллаж байна.

Шүүхийн цахим санд шийдвэрлэсэн хэргийн тойм, шүүх хуралдааны товыг байршуулж, цахим хуудсыг шинэчлэх, тогтмол баяжуулах ажлыг мэдээлэл технологийн мэргэжилтэн хариуцан зохион байгуулан ажиллаж байна.

Үйл ажиллагаа явуулж буй албан конторын гадна өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор засварын ажлыг өөрийн төсвөөр хийж гүйцэтгэлээ. Бусад зардлын тооцоог 2025 оны төсвийн төсөлд санал хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. Шүүхийн байрны аюулгүй байдал, шүүгч ажилтан нарын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг хангах зорилгоор Ховд аймгийн Ариунцэвэр, халдвар судлалын Улсын ариун цэвэрийн ерөнхий байцаагчид хандан хүсэлт тавьж шүүхийн байранд хортон шавьж устгуулж, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэлээ.



Шүүх хооронд хавтаст хэрэг зөөвөрлөх, түүний аюулгүй байдлыг хангаж, хүргэх зорилгоор “Монгол шуудан” ТӨХК-тай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс батлан гаргасан “Хавтаст хэрэг илгээх, хүлээн авах журам”-ын дагуу ус чийгээс хамгаалагдсан битүүмжлэл бүхий зориулалтын богцыг ашиглан шуудангаар хэрэг, хэргийн материалыг аюулгүй, шуурхай зөөвөрлөж байна.

Мөн байгууллагын гадна орчны хог хаягдал, түлш нүүрсний үнс, хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, шинээр түлш нүүрс буулгаж авах агуулах складыг бэлтгэн 70 тонн нүүрс тус шүүхийн тамгын газрын ажилтан нар буулгаж хураалаа.



Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын төлөвлөгөөний дагуу тус шүүх нь 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэлд зориулж байгууллагын орчны цас цэвэрлэж, байгууллагад хувиарлагдсан төсвийг хүрээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажилтай холбогдуулан гүний худаг, цэвэр усны хоолой хөлдөхөөс хамгаалж дулаалга хийлгэж, цэвэр бохир усны хоолойн бөглөрөлтийг хэвийн болгож, ус гоожиж буй радиаторуудыг засварлан, нөөц усны савны дулаалга холболтуудыг шалгаж уурын зуухны янданг гагнаж, шилэн хөвөнгөөр дулаалж, мотор, цахилгаан, сантехникийг үйл ажиллагааны доголдолуудыг засварлалаа.

Тус шүүхийн мэдлийн 2 га газрын хогийг цэвэрлэж хонхор газар нь шороо асган дүүргэж, талбайг тэгшлэн, торлон хамгаалж, тойруулан усалгаа хийх шуудуу татаж бэлтгэсэн байна. Мод тарих, ойжуулахад зориулж хөрсийг бэлдэх ажил явагдаж байна.



Хэргийн хөдөлгөөний удирдлагын системд нийт 25 хүсэлт хүргүүлсэн бөгөөд 7 хүсэлтийг буцааж 18 хүсэлт шийдвэрлүүлсэн байна. үүнээс 4 хүсэлт нь 1 асуудал дээр давхардаж очсон байна. Нууц үг шинээр авах, дугаар давхардах, үсрэх зэрэг асуудлаар хүсэлт хүргүүлсэн байх бөгөөд цаашид гарах хэрэглэгчийн алдааг багасгахын тулд дотоод сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Шүүхийн хүний нөөцийн програм дахь ажилтны мэдээлэл, түүний баяжилтанд хяналт тавьж шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нараар гарын үсэг зуруулан баталгаажуулж 6 сард Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн. Дахин хянуулж 12 сард хуулийн хугацаанд хүргүүлнэ.

Шүүхийн шийдвэрийн цахим хуудас /shuukh.mn/ дахь 2013-2023 оны шүүхийн шийдвэрүүдийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зөрчлийг бүрэн арилгасан.

Архивын данс бүртгэлийг холбогдох хууль журамд нийцүүлэн хөтөлж, нэгдсэн тооллогын мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2019- 2023 онд хянан шийдвэрлэсэн 405 эрүүгийн хэргийг Эрүүгийн хэргийн тусгай архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар батлуулж байнга хадгалах 35 хэргийг Эрүүгийн хэргийн тусгай архивт, 370 хэргийг Ховд аймгийн Прокурорын тамгын газрын архивт тус тус хүлээлгэн өгсөн байна.



Тамгын газрын дотоод нөөц бололцоог ашиглан архивын баримтыг цахимжуулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 137 хадгаламжийн нэгжийг цахимжуулаад байна

**ХОЁР: ШҮҮХИЙГ ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН  
АРГА ХЭМЖЭЭ**

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан орон тооны дагуу төрийн захиргааны 7 албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний 12 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нийт 22 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Дотоод зохион байгуулалтын хүрээнд тус шүүхийн шүүгч, ажилтнуудын хамтарсан зөвлөгөөнийг хийж хэвшсэн. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд ажлын туршлагын хувьд, шүүгчдийн 66.6 хувь нь шүүхэд 10-20 жил, 33.3 хувь нь 20-с дээш жил, шүүхийн захиргааны ажилтнуудын 21.2 хувь нь шүүхэд 1-5 жил, 36.5 хувь нь 5-10 жил, 42.3 хувь нь 10-аас дээш жил тус тус ажиллаж байна.

Тус шүүхийн тамгын газрын даргын 2024 оны 03 сарын 15-ны өдрийн 23 тоот албан бичгээр 2025 онд зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүсч буй орон тооны саналыг хүргүүлсэн байна.

2016 оны 05 сарын 13-ны өдрийн “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их хурлын 42 дугаар тогтоолоор батлагдсан болон одоо ажиллаж буй шүүгчийн тоо

| Шүүх                                            | Батлагдсан орон тоо | Томилогдсон шүүгч |
|-------------------------------------------------|---------------------|-------------------|
| Ховд аймгийн Булган сум<br>дахь Сум дундын шүүх | Ерөнхий шүүгч 1,    | Ерөнхий шүүгч 1   |
|                                                 | шүүгч 4             | шүүгч 2           |

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн 206 дугаартай тогтоол, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн 01/1554 дугаартай албан бичгийн дагуу тус шүүхийн тамгын газрын ажилтны орон тоо

| Д/Д | Албан тушаал                              | Батлагдсан<br>орон тоо | Томилогдсон<br>ажилтан |
|-----|-------------------------------------------|------------------------|------------------------|
| 1   | Шүүхийн тамгын газрын дарга               | 1                      | 1                      |
| 2   | Мэдээлэл, лавлагааны мэргэжилтэн          | 1                      | 1                      |
| 3   | Шүүгчийн туслах                           | 4                      | 3                      |
| 4   | Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга      | 3                      | 2                      |
| 5   | Мэдээллийн технологийн мэргэжилтэн        | 1                      | 1                      |
| 6   | Хүний нөөц, дотоод ажил хариуцсан шинжээч | 1                      | 0                      |

|    |                                                                                                            |   |   |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|
| 7  | Олон нийттэй харилцах мэргэжилтэн                                                                          | 1 | 0 |
| 8  | Эвлэрүүлэн зуучлагч                                                                                        | 1 | 1 |
| 9  | Эвлэрүүлэн зуучлалын туслах ажилтан                                                                        | 1 | 1 |
| 10 | Мэдээлэл технологийн инженер                                                                               | 1 | 0 |
| 11 | Ахлах нягтлан бодогч                                                                                       | 1 | 1 |
| 12 | Архивч                                                                                                     | 1 | 0 |
| 13 | Бичиг хэргийн эрхлэгч                                                                                      | 1 | 1 |
| 14 | Бичиг хүргэгч                                                                                              | 1 | 1 |
| 15 | Нярав                                                                                                      | 1 | 1 |
| 16 | Эмч                                                                                                        | 1 | 0 |
| 17 | Сэтгэлзүйч                                                                                                 | 1 | 0 |
| 18 | Төрийн үйлчилгээний бусад гүйцэтгэх ажилтан /Жолооч, мужаан, слесарь, цахилгаанчин, үйлчлэгч, галч, бусад/ | 7 | 5 |

ШЕЗ-с баталсан төсөвт тусгасаны дагуу 2023 оны 05 сараас эхлэн эвлэрүүлэн зуучлагчийн туслахын орон тоог нэмэгдүүлсэн.

Тамгын газрын даргын А/04 тоот тушаалаар ёс зүйн дэд хороо байгуулан ажлын төлөвлөгөө гаргуулж шүүхийн захиргааны ажилтан нарт ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоод сургалт зохион байгуулан ажиллаж байна.



Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны систем, Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь Төрийн албаны зөвлөлийн холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан, мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүний нөөцийн бүртгэлийн програм /courthr/-д шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын мэдээллийг хугацаанд нь

бүрэн зөв оруулж шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарт танилцуулан баримт үйлдэж шүүхийн ерөнхий зөвлөлийн холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

| №  | Байгууллага                                                  | Албан тушаал                     | Эцэгтэйгчийн нэр | Нэр        | Хайх | Цэвэрлэлт |
|----|--------------------------------------------------------------|----------------------------------|------------------|------------|------|-----------|
| 1  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Нярав                            | Мудай            | Баатарпил  |      |           |
| 2  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Галч                             | Хорлоо           | Баттуяа    |      |           |
| 3  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Санхүүгийн слесарь               | Чолбоол          | Баттуяа    |      |           |
| 4  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Мэдээлэл тээвэрлэх мэргэжилтэн   | Баттогтох        | Баярмагнай |      |           |
| 5  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Шүүхийн захиргааны хуульч        | Нягирал          | Гэгэдийн   |      |           |
| 6  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Бичиг хураагч                    | Юндэн            | Гэгэдийн   |      |           |
| 7  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Тамгын газрын дарга              | Цог-оюу          | Дэлгэр     |      |           |
| 8  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Холбоо                           | Базар            | Зоригт     |      |           |
| 9  | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Ерөнхий няглан бодол             | Баатаржав        | Мөнхбат    |      |           |
| 10 | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Архив-бичиг хариуцагч            | Баатаржав        | Мөнхбат    |      |           |
| 11 | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Галч                             | Шарга            | Нямдаваа   |      |           |
| 12 | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Мэдээлэл технологийн мэргэжилтэн | Балжинням        | Орванбал   |      |           |
| 13 | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Үйлдвэр                          | Ослод            | Орванбал   |      |           |
| 14 | Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн тамгын газар | Шүүхийн туслах                   | Хайрбаатар       | Орванбал   |      |           |

Мөн Шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын хувийн хэрэг, холбогдох материалыг зохих журмын дагуу шинэчлэх ажлыг зохион байгуулж шүүгч болон шүүхийн захиргааны ТЗ-6, ТУ-8-аас дээш шатлалаар цалинжиж буй ажилтан нарын хөрөнгө орлогын мэдүүлэгийг гаргуулан авч холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлээ.



2024 оны 05 сард Ховд аймгийн шүүхийн тамгын газрын Мэдээлэл технологийн мэргэжилтэнтэй хамтран Төрийн албаны тусгай шалгалт орон нутагтаа онлайнаар зохион байгууллаа. Тус шалгалтанд тус шүүхийн шүүгчийн туслах 1, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга 2 орж тэнцлээ.



Шүүн таслах ажлыг тасралтгүй хэвийн хэрэгжүүлэхийн тулд тус шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын ээлжийн амралтын хуваарийг батлаж, хуваарийн дагуу шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын ээлжийн амралтыг эдлүүлэн ажиллаа.

2024 оны 1 дүгээр улиралд шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарыг Монгол Улсын төрийн одон, медаль, цол, тэмдэг болон салбарын шагналд уламжлан материалыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

“Шүүхийн захиргааны цахим сургалтын систем”-д байршсан хичээлүүдийг шүүхийн захиргааны ажилтан нараар судлуулан ажиллаж байна.


Шүүгч нарын амь нас, эрүүл мэндийн даатгалын гэрээг байгуулж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн. Шүүхийн захиргааны ажилтан нарын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлд шүүхийн захиргааны 2 ажилтанд албаны орон сууцыг зохих журмын дагуу гэрээгээр эзэмшүүлж эзэмшилт, ашиглалтанд нь хяналт тавин ажиллаж байна.

**ГУРАВ: ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ,  
ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХОЛЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР  
ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах төлөвлөгөөг 2024 оны нэгдүгээр улиралд шинэчлэн баталж, төлөвлөгөөний хэрэгжилт болон бусад асуудлаар Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтарсан зөвлөгөөн, сургалтыг удирдамж, хөтөлбөр батлан улиралд нэг удаа зохион байгуулан ажиллаж байна.


Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нар Ховд аймгийн Онцгой байдлын газрын Булган сум дахь Онцгой байдлын хэлтсийн заавар, зөвлөмжийн дагуу бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл авах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтанд идэвхитэй оролцож гамшгийн үед хэрхэн ажиллах талаар зааварчилгаа авлаа.

Мөн Галын аюулгүй байдлын тухай хуулийн дагуу Ховд аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын байцаагчаар дүгнэлт гаргууллаа.




Эрэн сурвалжлах, албадан ирүүлэх програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн үр нөлөөг сайжруулах зорилгоор Цагдаагийн хэлтэстэй хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж захирамж, шийдвэрийн биелэлт үр дүнг тооцон ажиллаа.

Шүүх хуралдааны журам сахиулагч болон шүүхийн байрны аюулгүй байдлыг хангах харуул хуяг батлагдсан орон тооны дагуу бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн санхүүжилтээр шүүхийн байрны гадна болон дотор хяналтын камерыг иж бүрэн шинэчилэн, сольж суурилууллаа.



Шүүхийн дотоод сүлжээний зохион байгуулалтыг сайжруулан, сүлжээний зураглал, хаягжилт хийж Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн свитчүүдийг сольж суурилуулан ажиллаж байна. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 07 сарын 01-ны өдрийн 95 дугаартай шүүхийн байрны нийтлэг шаардлага батлах тухай тогтоолын 2.5.2 болон 2.5.5 дугаар зүйлд заасны дагуу Сервэрийн өрөө болон түр саатуулах өрөөг тохижуулж камержуулсан байна. Мөн уг тогтоолын 2.6 дугаар зүйлд заасны дагуу цахилгаан тасарсан, хязгаарлалт хийсэн үед ашиглах цахилгааны нэмэлт эх үүсгэвэртэй байна.



Тайлант онд тус шүүхийн шүүгч нараас нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгч байхгүй бөгөөд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдол гараагүй байна.

2024 онд тус шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нар нийт 24 удаа Ховд аймгийн Эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүх бүрэлдэхүүнд орж ажилласан байна. Шүүн таслах ажлын хэвийн тасралтгүй байдал, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үүднээс тус шүүхийн ХОУ4360 улсын дугаартай PRADO-150, ХОУ5360 улсын дугаартай RENAULT DUSTER авто машинуудыг компьютер оношлогоонд бүрэн оруулж рулийн аппарат, кондейшны мотор, цапны шарик зэргийг сольж шинээр тавьсан бөгөөд өвлийн улиралд зориулж бүх дугуйг нь шинээр сольсон бөгөөд нийт 6 орчим сая төгрөгний зардал гарсан байна.



Байгууллагын дотоод нөөц бололцоо болон шүүхийн захиргааны ажилтан нарын санаачлагаар тус шүүхийн албан конторын барилгын гаднах 180 м<sup>2</sup> автомашины зогсоолыг цементээр цутгаж бордюр суулгалаа.



Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан эд мөрийн баримт устгах комисс 2024 оны 07 сар болон 11 саруудад шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр болсон, шийтгэх тогтоолд устгахаар заасан эд мөрийн баримтуудыг боломжит аргаар устгаж шүүхийн эд мөрийн баримт устгах цэгт шатаан устгалаа.

2023 оны ХАСХОМ мэдүүлэх ажлыг тамгын газрын хэмжээнд шуурхай зохион байгуулж холбогдох тайлан мэдээг хуулийн хугацаанд нь Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

**ДӨРӨВ: ШҮҮХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГААГ ХАНГАХ  
ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн тамгын газарт 2024 онд 1,142,691.0 мянган төгрөгний төсөв батлагдаж, 11-р сарын тайлант үед 1,114,646.00 мянган төгрөгийн санхүүжилт авч 11-р сарын төсвийн гүйцэтгэлээр 1,004,068.1 төгрөгнийг 12 бүлгийн 31 нэр төрлийн зардалд зарцуулж, төсвийн мөнгөний зарцуулалтанд хуулийн хүрээнд хяналт тавьж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаа.

Шүүхийн 2024 оны хөрөнгийн хөдлөлийн судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөл болон Төрийн өмчийн хороонд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

Шүүхийн 2025 оны төсвийн төслийг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, төсвийн төслийн танилцуулгыг холбогдох газарт нь хүргүүллээ.

Нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөж, байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах зорилгоор нягтлан бодогчийн үйл ажиллагааны тайланг улирал бүр хамт олны зөвлөгөөн дээр танилцуулан ажиллаж байна.

Татвар, нийгмийн даатгал, шилэн дансны, тайланг хуулийн хугацаанд сар, улирал, жилээр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж батлагдсан төсвийн хүрээнд өр, авлага үүсгэхгүйгээр ажиллаж байна.

Шилэн дансны тухай хууль, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2015 оны 01 сарын 20-ны 6 тоот тушаалын дагуу хуулийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улирлын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж, Төсвийн гүйцэтгэлийн мэдээг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд /1-11 сарын мэдээ/ хүргүүлсэн. Мөн үндсэн хөрөнгө шинээр олж авах, шилжүүлэх, актлах, дахин үнэлэх талаар саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг тамгын газрын даргын тушаалаар томилогдсон комисс данс бүртгэлтэй тулган нэг бүрчлэн тоолж дүнг илтгэх хуудсаар 2-р улирал болон 4-р улирлаар тайлагнаж ажиллаж байна.

Тус шүүхийн 2023 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын харьяа Ховд аймгийн аудитын газрын аудитын дүгнэлтээр “өөрчлөлтгүй” санал, дүгнэлт

авсан. Аудитын дүгнэлтийг холбогдох материалын хамт Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитын газар хүргүүлсэн болно.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах, шилжүүлэх эсхүл дахин үнэлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

2024 оны Худалдан авах бараа ажил үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүллээ.

**ТАВ: МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН  
АРГА ХЭМЖЭЭ**

Ховд аймгийн Булган сумын 10000 гаруй иргэдэд шүүхийн үйл ажиллагааны талаархи мэдээ, мэдээллийг хүргэх, шүүхээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж, цар хүрээг өргөжүүлэх шүүхийн үйлчилгээг ойртуулах, тэдэнд хүрч ажиллах ажлын үр дүнг дээшлүүлэх, цахим болон бусад хэлбэрээр шүүхийн талаархи мэдээллийг тухай бүр шуурхай хүргэхэд бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр Ховд аймгийн Булган сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг байгууллаа

Иргэн төвтэй шүүхийн үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх зорилтын хүрээнд шүүхээс мэдээлэл авах, шүүхэд мэдүүлэх эрхээ үр нөлөөтэй эдлэх нөхцлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэж ажилласан.

Шүүхийн тамгын газар нь шүүхийн үйл ажиллагааны талаархи эерэг мэдээллийг дамжуулах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн богино хэмжээний шторкийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан хүргэж, шүүн таслах ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зорилтын хүрээнд шүүх хуралдааны үйл явцыг олон нийтэд ажиглах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн нээлттэй шүүх хуралдааныг “Нээлттэй шүүх” танхимд байрлуулсан дэлгэцээр цацаж шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өөрийн шүүхийн цахим хуудас болох [court26.kho.gov.mn](http://court26.kho.gov.mn), “Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүх” пасабүүк хуудас, [Judcouncil.mn](http://Judcouncil.mn)-ээр тогтмол мэдээллэж байгаа нь олон нийтийн итгэлийг дээшлүүлсэн үйл ажиллагаа болж байна.



Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь тодорхой төрлийн маргааныг эвийн журмаар, шүүхийн бус аргаар шуурхай зардал багатай шийдвэрлэх таатай нөхцлийг бий болгосоноор Сум дундын шүүхийн ажлын ачаалалыг багасгасан нь үр дүнгээ өгч байна. Тус шүүхийн эвлэрүүлэн зуучлагч нь харьяа сум орон нутгийн дэлгүүр олон нийтийн газраар явж эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны талаар танилцуулга, мэдээлэл хийж гарын авлага, боршур тарааж ажиллаа.

Монгол улсын хууль тогтоомж, төрийн албаны зарчим, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”-д нийцүүлэн иргэд олон нийтэд хүндрэл, чирэгдэл учруулалгүй түргэн шуурхай үйлчилж ажлын байранд ажил хэрэгч уур амьсгал бүрдүүлэн үйлчилгээний чанарыг сайжруулахыг гол зорилго мэдээлэл лавлагааны алба, нээлттэй шүүх танхимын тохижилтонд анхаарч, иргэд олон нийт үйлчилгээ авах нөхцөл боломжийг сайжруул, хэрэгцээт мэдээллээ авах боломжоор хангасан.

Тус шүүх нь харьяа сумуудад нүүдэллэн ажиллахдаа уулзалт, ярилцлагын хэлбэрээр болон тус сумын захиргааны байранд байрлуулсан шүүхийн мэдээллийн самбар, гарын авлага тараах материалаар сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүх хуралдааны товыг хэргийн оролцогч болон шүүхийн иргэдийн төлөөлөгчдөд хүргэх, мэдэгдэх ажлыг шуурхай зохион байгуулж шүүх хуралдааны бэлтгэл дутуу хангасан үндэслэлээр тайлангийн хугацаанд шүүх хуралдаан хойшлоогүй байна

“Нээлттэй шүүх танхим”-д иргэд, хуулийн этгээдэд зориулсан шүүхийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, хуулийг сурталчилсан боршур гарын авлага материал бэлтгэн, дэлгэцээр шүүхийн тухай багц хууль сурталчилсан шторк цацаж байна.

Шүүхийн мэдээллийн самбарт, хууль тогтоомж, холбогдох мэдээллийг байршуулах, мэдээллийг шинэчлэн баяжуулж олон нийтийг мэдээллээр хангах ажлын хүрээнд Youtube.com, legalinfo.mn, Judcouncil.mn, болон Facebook цахим хуудаснаас эх сурвалж, үндэслэл нотолгоотой мэдээллүүдийг авч цаг алдалгүй шинэчлэн баяжуулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Нээлттэй шүүх танхимын дэлгэцээр шүүх хуралдааныг олон нийтэд хүргэхээс гадна шүүх хуралдаан дууссан үед Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан шторк, мэдээллүүдийг цацан иргэд олон нийтийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Шүүх хуралдааны танхимын дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжийн хэвийн ажиллагааг мэдээлэл технологийн мэргэжилтэн хариуцан шаардлагатай засвар үйлчилгээг хийн ажиллаж байна.

Тус шүүх нь “court26.kho.gov.mn” вэб хуудас болон “Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүх” пасебүүк хуудсаар онцлох үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

Тус шүүх нь орон нутгийн чанартай үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр идэвхитэй оролцож нутгийн захиргааны байгууллагатай болон бусад төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж иргэдийн хууль эрх зүйн боловсролд зориулсан сургалт сурталчилгааг удаа дараа зохион байгуулж ирсний дээр орон нутгаас зохион байгуулсан бүх нийтээр оролцох ажилд хамт олноороо идэвхитэй оролцож байлаа. Тухайлбал: Цэргийн баяр угтсан Байлдааны гавьяаны одонт, Цэргийн алдар алтан медальт, монгол улсын баатар, армийн генерал Б.Доржийн нэрэмжит Хилийн цэргийн 0130 дугаар ангиас "Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчний 103 жилийн ойн баяр, Хилийн отрядын 91 жилийн ойд зориулан Ховд аймгийн Булган, Алтай, Үенч сум дахь Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулсан марш такт, спортын олон төрөлт тэмцээнд тус шүүхийн хамт олон амжилттай оролцлоо.



Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүх, Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Прокурорын газар, Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн албан хаагч нарын дунд “Хөдөлгөөн – эрүүл мэнд” аян өрнүүлж зохион байгуулсан тэмцээн уралдаанд тэргүүн, дэд байр эзэлсэн албан хаагч нарт 3-н байгууллагын удирдлага гарын бэлэг гардууллаа.



Тус шүүхийн ахмад ажилтан галч Ч.Батхүү нь 17 дугаар жарны “Хилэнт эх” хэмээх модон луу жилийн сар шинийн босгон дээр Ховд аймгийн Булган сумын төрийн байгууллагуудын 2023 оны үйл ажиллагааны үнэлгээгээр “Төрийн үйлчилгээний тэргүүний ажилтан”-аар шалгарсан тул хүндэтгэл үзүүллээ.



Бүгд найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулан Ховд аймгийн Булган сумын залуучуудын дунд хууль сурталчлах, залуучуудын эв нэгдэл, бие бялдарыг хөгжүүлэх, алслагдмал орон нутагт 3х3 сагсан бөмбөгийн төрлийг дэлгэрүүлэх зорилгоор 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



**НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ  
САЙЖРУУЛАХ САНАЛ**

Тус шүүхийн тамгын газар хуулиар хүлээсэн ажил үүргээ хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ. Цаашид шүүхийн тамгын газраас дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Тус шүүх нь 2012 онд Дэлхийн банкны санхүүжилтээр баригдаж ашиглалтанд орсоноос хойш одоог хүртэл их засвар, өргөтгөл хийгдээгүй бөгөөд цаашид хүүхдийн өрөө, амралтын өрөө, өмгөөлөгч, прокурор хэрэгтэй танилцах өрөө болон архивын өрөө, шинээр томилогдсон албан хаагч нарын албан өрөө, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн уулзалтын өрөө дутагдалтай байна. Мөн нэг хүнд ногдох талбайн хэмжээ, иргэд олон нийтэд үйлчлэх зай талбайн хэмжээ хүрэлцэхгүй байх тул шинээр өргөтгөл барих шаардлагатай байна. Иймд зураг төслийг саналын хамт Шүүхийн ерөнхий зөвлөлд хүсэлт тавин шийдвэрлүүлэх.

- Шүүхийн мэдлийн 2 га газрыг ойжуулан тохижуулах ажлыг үргэлжлүүлэн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарын нийгмийн баталгааг хангах үүднээс орон сууцны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд бэлтгэх

- Тус шүүх нь эрүүгийн хэргийн нэгдсэн системд холбогдоогүй тул Ховд аймгийн шүүхийн Тамгын газарт компьютер байрлуулж anydesk програм ашиглан хандаж эрүүгийн нэгдсэн системд ажиллагаа хийж байгаа бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлд уламжлан шийдвэрлүүлэх

ТАЙЛАН БИЧСЭН:

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМ ДАХЬ

СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ДЭЛГЭР